

Сонгох даалгавар /Биологи/

1. Дараах амьтад хөвчтөний хүрээний ямар ангийн төлөөлөгч вэ? Зөв харгалзуулаарай.
/ 2 оноо/

- | | |
|---------------------|-----------------------------|
| 1.Загас | А. Гүлмэр, саламандар |
| 2.Хоёр нутагтан | Б. Матар, яст мэлхий |
| 3.Мөлхөгчид | В. Тул, зэвэг, хадран |
| 4.Шувуу | Г. Сарьсан багваахай, зараа |
| 5.Сүүгээр бойжигчид | Д. Хөтүү, ногтруу |

- | | |
|-----------------------|-----------------------|
| А. 1Д, 2Б, 3А, 4В, 5Г | Б. 1В, 2Б, 3А, 4Д, 5Г |
| В. 1В, 2А, 3Б, 4Д, 5Г | Г. 1А, 2В, 3Б, 4Г, 5Д |

2. Зураг дээрх амьтан бол..... юм. /1 оноо/




- А. 4 хос хөлтэй, трахейгаар амьсгалдаг толгой цээж хэвлий гэсэн хэсэгтэй
 Б. 3 хос хөлтэй, далавчтай, трахейгаар амьсгалдаг, бие нь 3 хэсэгтэй
 В. 5 хос хөлтэй, далавчтай, уушгиар амьсгалдаг, бие нь 2 хэсэгтэй
 Г. 4 хос хөлтэй уушгиар амьсгалдаг, бие нь 3 хэсэгтэй

3. Нүүрс усны мономер нэгжийг сонгоно уу. /1 оноо/

- А. амин хүчил Б. тосны хүчил В. глюкоз Г. глицерин

4.Нэгэн нүүрс усны бүтцийг бүдүүвчээр үзүүлжээ. Энэ бодисын нэр болон үүргийг зөв илэрхийлсэн хувилбарыг сонгоно уу. /1 оноо/



- А. Сахароз, флоэмийн шингэнээр зөөвөрлөгдөх
 Б. Цардуул, энергийн эх үүсвэр болон хуримтлагдах
 В. Эслэг, навчинд үүсэж, энергийн эх үүсвэр болон хуримтлагдах
 Г.Эслэг, эсийн хананы бат бөх байдлыг хангах


5. Энзимийг бүтээгч бодис аль нь вэ? /1 оноо/

- А. Нүүрс ус Б. Өөх тос В. Нуклеотид Г. Уураг

6. Уургийг задалдаг энзимийн төрлийг сонгоорой. /1 оноо/


- А. Липаза Б. Протеаза В. Нуклеаза Г. Карбогидраза

7. Энзимийн бүтцийн зургаас идэвхтэй төв ба субстратыг ялган тэмдэглэнэ үү. /1 оноо/



- А. 1 ба 2
 Б. 2 ба 3
 В. 3 ба 4
 Г. 1 ба 4

8.Зурагт үзүүлсэн үйл явц хоол боловсруулах эрхтний аль хэсэгт ямар энзимийн оролцоотой явагддаг вэ? /1 оноо/



- А. Амны хөндийд амилаза энзимийн оролцоотой.
- Б. Нойр булчирхайд липаза энзимийн оролцоотой.
- В. Ходоодонд протеаза энзимийн оролцоотой
- Г. 12 хуруу гэдсэнд мальтоза энзимийн оролцоотой

9. Эндоплазмын торын үүргийг нэрлэнэ үү. /1 оноо/




- 1. Шим тэжээлийн бодис нийлэгжүүлэх
- 2. Шим тэжээлийн бодис хадгалах
- 3. Шим тэжээлийн бодис зөөвөрлөх
- 4. Шим тэжээлийн бодис ялгаруулах
- 5. Шим тэжээлийн бодис нөөцлөх

А.2,3 Б.1,2 В.1,3 Г.3,5

10. Ургамлын эсэд байдаг амьтны эсэд байдаггүй эрхтэнцрийг олж тэмдэглээрэй. /1 оноо/

А. Цитоплазм Б. Плазман мембран В. Пластид Г. Рибосом

11. Хромосомын бүтцийн зургийг ажиглан тайлбарыг зөв илэрхийлсэн мөрийг сонгоно уу. /1 оноо/



	1	2	3	4
А	Хромосомын мөр	Центромер	Хроматид	ДНХ-ийн молекул
Б	Центромер	Хромосомын мөр	ДНХ-ийн молекул	Хроматид
В	Центромер	ДНХ-ийн молекул	Хроматид	Хромосомын мөр
Г	Центромер	Хроматид	ДНХ-ийн молекул	Хромосомын мөр

12. Дараах эрхтэнцрийг нэрлэнэ үү?

/1 оноо/



- А. Бөөм Б. Митохондри
- В. Пластид Г. Эндоплазмын тор

13. Дамжуулах багцын хэлбэрүүдийг ажиглаад ургамлын эрхтнүүдийн аль хэсэгт байрладаг болохыг зөв харгалзуулсан хувилбарыг сонгоно уу. /2 оноо/

1	2	3
		
А. Үндэсний дамжуулах багц	В. Ишний дамжуулах багц	С. Навчны дамжуулах багц

A.1c 2b 3a

В.1a 2c 3b

С.1b 2c 3a

D.1a 2b 3c

14. Цусны ялтас эсийн амьдрах хугацаа хэд вэ? /1 оноо/

А. 5-8 хоног

Б. 8-10 хоног

В. 14 хоног

Г. 21 хоног

15. Зөв харгалзуулсан хувилбарыг ол. /2 оноо/

1. Улаан эс

а. Бөөмтэй, гадны элдэв өвчин үүсгэгчдээс хамаалах

2. Цагаан эс

б. Бөөмгүй, хүчилтөрөгчөөр баялаг

3. Ялтас

в. бөөмгүй, цус бүлэгнэх төлжүүлэхэд гол үүрэгтэй

А.1В 2А 3Б

Б. 1Б 2В 3А

В. 1Б 2А 3В

Г. 1В 2Б 3А

16. Агаар дамжуулах хэсгийн бүтцийг зөв дарааллуулан байрлуулсан хувилбарыг ол. /1 оноо/

А. Хамрын хөндий, төвөнх, мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушги

Б. Хамрын хөндий, төвөнх, гуурсан хоолой, мөгөөрсөн хоолой, уушги

В. Хамрын хөндий, гуурсан хоолой, төвөнх, мөгөөрсөн хоолой, уушги

Г. Хамрын хөндий, төвөнх, улаан хоолой, гуурсан хоолой, уушги

17. Доорх нөхцлүүдийн аль нь сүрьеэгээр өвчлөх эрсдлийг нэмэгдүүлэх вэ? /1 оноо/

1. ариутгаагүй сүү уух

2. хаягдал усанд амьдарч буй хавч хэлбэртнийг хүнсэнд хэрэглэх

3. хүн амын хэт нягтралтай нөхцөлд амьдрах

А.1 ба 2

Б.1 ба 3

В.2 ба 3

Г. зөвхөн 3

18. Өвчин үүсэх зарим шинжүүдийг жагсаан бичжээ. /1 оноо/

1. эцэг эхээс удамшиж болно.

2. дамжуулагчаар зөөвөрлөгдөж болно.

3. стрессээс шалтгаалан үүсч болно.

4. хүрэлцэх үед дамжиж болно.

5. хоол хүнстэй хамт амаар дамжин орж болно.

Эдгээрээс аль нь халдварт өвчний шинжүүд вэ?

А.1,2 ба 3

Б.1,3 ба 5

В.2,3 ба 4

Г. 2,4 ба 5

19. Антибиотикоор эмчлэгддэг өвчнийг олно уу. /1 оноо/

А. холер болон сүрьеэ

Б. ХДХВ/ДОХ болон цагаан бурхан

20. Зөв харгалзуулна уу? /1 оноо/

1. халдварт бус өвчин а. Өвөрмөц үүсгэгчээр үүсгэгдэж, халдвар тараадаг, үечилсэн явцтай, өвөрмөц дархлаа тогтдог, өргөн хүрээний бүлэг өвчин.
2. халдварт өвчин б. Энэ бол хүний эс үржиж хуваагдах, ялгарах зэрэг хэвийн үйл ажиллагааны бүтцээ алдаж өөрчлөгдсөнмий улмаас үүссэн хэт ургалт юм.
3. хавдар в. бие мхбодын бүтэц зүйн хэвийн байдал алдагдах ба бусад биед ямар нэгэн замаар халдварлахгүй тухайн бодгаль өвчилдөг.

А. 1Б 2А 3В

Б. 1А 2В 3Б

В. 1В 2Б 3А

Г. 1В 2А 3Б

21. Хөхүүл ханиадаар өвчлөгсдийн тоо жил ирэх тусам нэмэгдсээр байна. Жирэмсэн эмэгтэйн шинэ төрөх хүүхдийг хөхүүл ханиаднаас хамгаалахын тулд вакцинжуулалтад хамруулдаг. Ээжийн дархлааны хариу үйлдэл шинэ төрсөн хүүхдийг хөхүүл ханиаднаас хэрхэн хамгаалах вэ? /2 оноо/

	<i>хүүхэд төрөхөөсөө өмнө эхээсээ авах</i>	<i>хүүхдийн авсан дархлааны төрөл</i>
A	эсрэг бие	төрөлхийн идэвхгүй
B	эсрэгтөрөгч	олдмол идэвхтэй
C	санамжийн эс	олдмол идэвхгүй
D	өвчин үүсгэгч	төрөлхийн идэвхтэй

22. Гоц халдварт өвчний дэгдэлтийн үед эмзэг бүлгийн хүмүүст яаралтай тусламж хэрэгтэй болдог. Эдгээр хүмүүст ямар төрлийн дархлаа суулгах шаардлагатай вэ? /1 оноо/

	төрөлхийн	олдмол
идэвхтэй	A	B
идэвхгүй	C	D

23. ДНХ-ын репликац эсийн мөчлөгийн аль үе шатанд явагдах вэ? /1 оноо/

- А. Интерфаз үе шат Б. Профаз үе шат В. Метафаз үе шат Г. Анафаз үе шат

24. Эсийн нэг хуваагдлаас дараагийн хуваагдлын хоорондох үе шатыг гэх ба энэ нь үе шатнаас тогтоно. /2 оноо/

- А. Эсийн мөчлөг, 3 Б. Эсийн хуваагдал, 2 В. Интерфаз, 3 Г. Митоз хуваагдал, 4

25. Митоз хуваагдлын биологийн ач холбогдол /2 оноо/

1. Амьд бие махбодын өсөлтийн үндэс болно. 2. Бэлгийн бус үржлийн үндэс болно
3. Бэлгийн үржлийн үндэс болно. 4. Эд эсийн нөхөн төлжилтийг хангана.
5. Дархлааны хариу урвал митоз хуваагдлаас хамаарна.
6. Митоз хуваагдлын үр дүнд бэлгийн эсүүд үүснэ.

- А. 1,3,5,6 Б. 1,2,3,4 В. 3,4,5,6 Г. 1, 2, 4, 5

26. ДНХ-ийн бүтцийг нээснээр биологийн шинжлэх ухаанд амьд биеийн мэдээллийг хадгалах, энэ мэдээллийн дагуу нийлэгжих, мэдээллийг дараагийн удамд үйл ажиллагааг тайлбарлахад нэн чухал үүрэг гүйцэтгэсэн. /1 оноо/

А.Уургийн, ДНХ, дамжуулах

Б. Удамшлын, ДНХ, дамжуулах

В. Удамшлын, уураг, дамжуулах

Г.Удамшлын, мэдээлэл, дамжуулах

27. ДНХ-ийн нэг гинжний ТГА гэсэн азотлог суурьтай нөгөө гинжний ямар азотлог суурь холбогдох вэ. /1 оноо/

А. ГЦУ

Б.АЦТ

В. ТГА

Г. ГЦТ

28. Шим бодисыг бүрэлдүүлэхдээ гэрлийн энергийг ашиглаж байвал , химийн холбооны энергийг ашиглаж байвал организм гэнэ. Бэлэн органик бодисоор хооллодог организмыг , харин ургамал амьтны ялзмагыг задалж эрдэс бодис болгодог организмыг гэнэ. /1 оноо/

А.Фототроф, хемотроф, гетеротроф, задлагчид

Б. Хемотроф, фототроф, гетеротроф, задлагчид

В.Фототроф, хемотроф, сапрофит, гетеротроф

Г. Гетеротроф, хемотроф, фототроф, сапрофит

29. Популяцийг эзлэн орших газар нутгийн хэмжээ, амьдралын төлөв, онцлог, тархан дэлгэрсэн муж, бүс, бүслүүрийн байдлаар нь хэрхэн ялгаж үздэг вэ. /2 оноо/

А.Экологийн, газарзүйн

Б. Эгэл, газарзүйн

В. Эгэл, экологийн, газарзүйн популяци

Г. Эгэл, экологийн популяци

30. Аэроб амьсгалаар глюкоз задарчээ. Энэ процессоор үүссэн бодисууд ямар эргэлтэнд оролцох вэ? /1 оноо/

А.Нүүрстөрөгчийн эргэлт


Б.Нүүрстөрөгч болон усны эргэлт

В. Зөвхөн усны эргэлт

Д.Энергийн болон усны

Задгай даалгавар

31. Нэгэн энзимт урвалыг бүдүүвчид харуулжээ. W, X, Y бүтцийг дараах үгсийг ашиглан нэрлэнэ үү. Нэрлэх үгс: Бүтээгдэхүүн, субстрат, энзим /3 оноо/




W-..... X-..... Y-.....


32. ДНХ, РНХ-ийн үндсэн ялгааг нөхөж бич. /3 оноо/

№	Ялгаа	ДНХ	РНХ
1	Азотлог суурь	АГЦТ	1.....
2	Нүүрс ус	2.....	рибоз
3	Полипептидийн гинжний тоо	2	3.....
4	Байрлал	бөөмөнд	Цитоплазмд

33. Идэвхтэй ба идэвхгүй дархлааны төрлийг харуулсан бүдүүвчийг гүйцээж нөхнө үү. /4 оноо/



34. Зургийг ажиглаад митоз хуваагдал ямар үе шатуудыг нэрлээрэй. /3 оноо/



1. Интерфаз

2.....

3.....

4.....

5. Телофаз

35. Байгаль дах нүүрстөрөгчийн эргэлтийг бүдүүвчээр үзүүлжээ. Фотосинтез явагдаж байгаа үе шатын үсгэн тэмдэглэгээг бичнэ үү. /2 оноо/

